



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 3 сарын 17 өдөр

Дугаар А/ОН

Номгон

Байгууллагад үндсэн хөрөнгө орлогод авч,
бүртгэх тухай

Монгол улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.1, 14.2.2 дахь заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2, 14.4.5 дахь заалт, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, хасах, шилжүүлэх журам"-ын 4.1, 4.1.1, 4.1.3, 8.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Батлагдсан төсвийн хөрөнгөөр худалдан авсан 1 ширхэг Hana маркийн хөргөгчийг 698,690 (Зургаан зуун ерэн найман мянга зургаан зуун ер) төгрөгөөр байгууллагын үндсэн хөрөнгөд орлогод авч, бүртгэсүгэй.

2. Дээрх үндсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд тусгаж, тайлагнаж ажиллахыг Ахлах нягтлан бодогч (Д.Мөнхтуяа)-д зөвшөөрсүгэй.

3. Үндсэн хөрөнгийн шинж чанар, биет байдалд хяналт тавьж, орлогод авах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу хийж ажиллахыг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн дарга (Н.Энх-Амгалан)-д үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод хяналт шалгалтын мэргэжилтэн (Б.Ууганбаяр)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР

ӨРЛӨН ГҮЙЦЭТГЭГЧ

Н.БЯМБАДОРЖ



642401191

